

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛНА



ГАРААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллага сүүлийн 25 жилд томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийж, үүний хүрээнд эрх зүйт төрт ардчилсан нийгмийн үндсэн зарчмуудыг шүүх эрх мэдлийн байгууллагад нутагшуулах, авлигатай тэмцэх зэрэг зорилгуудыг дэвшүүлэн ажилласан. Монгол Улсын анхан шатны 90 шүүхэд нийт 369 шүүгч, 420 шүүхийн захиргааны ажилтан (ШЗА) ажиллаж байна. Одоогийн байдлаар ШЗА-ыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх бие даасан сургалтын тогтолцоо байхгүй бөгөөд шинэ ШЗА-ыг 90 хоногийн сургалтаар бэлтгэж байгаа нь шүүхийн захиргаа мэргэшсэн, тогтвортой албан хаагчдаас бүрдсэн байх гэсэн шаардлагыг хангаж чадахгүй байна. Тиймээс мэргэшсэн ШЗА-ыг бэлтгэх, давтан сургах хэвшсэн сургалтын тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд хөндөх өөр нэг асуудал нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (ХХША) ачаалал юм. Хүний нөөцийн хүрэлцээгүйгээс болж ХХША-ны хуульд заасан хугацаа хэтрэх, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдэд явдал чирэгдэл үүсэх, улмаар шүүхийн шүүн таслах ажиллагааны чанарт муугаар нөлөөлөх нөхцөл бүрддэг. 2018 онд “e-Justice” буюу хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн сан, цахим сүлжээг нийт цагдаа, шүүх, прокурор болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад нэвтрүүлсэн. Цахим сүлжээнд холбогдсон байгууллагууд уг сан, цахим сүлжээг ашигласнаар хэргийн талаарх мэдээллийг хурдан шуурхай, найдвартай сувгаар харилцан солилцох боломжтой болсон. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг богиносгох сайн талтай.

Шүүхийн хүний нөөцийн болон техникийн чадавхыг дээшлүүлэх, тогтвортой эрх зүйн орчныг бий болгох нь шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны үр өгөөжийг сайжруулах үндсэн суурь байдаг. Эрх зүйн шинэтгэлийн хэрэгжилтийн хувьд ахиц дэвшилт гарч байгаа хэдий ч хүний нөөцийн болон техникийн дутмаг байдлаас хамааран, чадавх, үйл ажиллагааны үр өгөөжийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа хэвээр байна.



Хууль зүй, дотоод хэргийн сайд Х. Нямбаатар шүүхийн захиргааны мэргэшсэн албан хаагчийн сургалтын төв байгуулах ажлын хэсгийг хүлээн авч уулзав

Захиалагч	Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)
Төсөл хэрэгжих бүс, нутаг	Монгол Улс
Хамтран хэрэгжүүлэгч	Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ)
Хэрэгжих хугацаа	2020 -2023



ЗОРИЛГО

Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагуудын чадавхыг сайжруулна. Төслийн зорилтууд:

- Шүүхийн мэргэшсэн захиргааны ажилтан бэлтгэх, давтан сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- Шүүх эрх мэдлийн байгууллагуудыг цахимжуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- Эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх, тухайлбал иргэний, бизнесийн хууль тогтоомжийг сайжруулах суурь нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.



Төрийн ордон



Уул уурхайн эрх зүйн салбар дахь хамтын ажиллагаа



НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- ШЗА бэлтгэх, давтан сургах сургалтын төв байгуулагдсан байна. Энэхүү төв нь онол практикийг хослуулсан буюу “дуаль” сургалтын системтэй байна.
- Шүүх эрх мэдлийн байгууллагуудын захиргааны ажилтнуудын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлого боловсруулагдсан байна.
- Улсын хэмжээнд зохион байгуулагдаж ирсэн иргэний хэргийн шүүгчийн сургалтыг үргэлжлүүлж, чадавхыг дээшлүүлсэн байна.



Шүүгч-багш нарын сургалт



ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын цахимжуулалт хариуцсан нэгдсэн алба байгуулагдсан байна.
- Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн цахим сүлжээнд Иргэний порталыг холбож, эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа үр өгөөжтэй, ил тод, түргэн шуурхай болсон байна.



Шүүхийн ерөнхий зөвлөлийн туршлага судлах аяллын гишүүдийг Франкфурт Майн хот дахь Мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ноён Роман Позек хүлээн авч уулзав



ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дурдсан эдийн засгийн хууль тогтоомжийн төслүүдийг иргэд, аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор хэлэлцүүлэгдэж, боловсруулагдсан байна.
- Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой зарим хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт хийгдсэн байна.
- Түншлэгч байгууллагуудын уул уурхайн салбар дахь олон улсын гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ хэлэлцээрт эрх зүйн дүгнэлт хийх чадвар, чадавх дээшилсэн байна.
- Шүүх эрх мэдлийн байгууллагуудын хүрээнд авлигатай тэмцэх ажлыг BMZ-ын “Governance-Fonds” төслийн арга хэмжээтэй уялдуулж хэрэгжүүлсэн байна.



e-Justice

Хэвлэлтийг: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)
Холбоо барих: "Шүүх, эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадавхыг сайжруулах" төсөл
Германы Олон Улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэг (GIZ)
Хууль зүй, дотоод хэргийн яам
Засгийн Газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: +976 11 326575; 327696
Факс: +976 11 325733
И-мэйл: lkhangva.zaya@giz.de
Вэб хаяг: www.giz.de/mongolia



Төслийн удирдагч: Л. Заяа
Дизайн /Зураг: Монгол Улс дахь GIZ төсөл
Хэвлэсэн: "Эдмаркет" ХХК
Огноо: 2021 оны 11 сар

Агуулгыг Монгол Улс дахь GIZ хариуцна.

Хамтран хэрэгжүүлэгч: Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам



Захиалагч: ХБНГУ-ын Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

Хаяг: BMZ Bonn
Postfach 12 03 22
53045 Bonn
Т +02 28 / 9 95 35-0
F +02 28 / 99 10 53 5-35 00

BMZ Berlin
Stresemannstraße 94
10963 Berlin
Т +030 / 1 85 35-0
F +030 / 1 85 35-25 01